



**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН
МАТЕРИАЛ**

Агуулга:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хөтөлбөр
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал:
 - Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн үндэслэлтэй танилцах;
 - Компанийн 2023 оны оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж, батлах;
 - "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох;
 - "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэж, батлах;
 - "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмын төсөлтэй танилцах;
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн талаар авах зарим арга хэмжээний талаар хэлэлцэж, шийдвэрлэх.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төсөл
8. Саналын хуудасны загвар

MONGOLIAN
STOCK EXCHANGE

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 05 дугаар тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлаж байна.

Компанийн оноосон нэр: "МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ТӨХК

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Д.Сүхбаатарын талбай-3

Хурал болох газар: Монгол Улс, Улаанбаатар хот, Ерөнхий сайд А.Амарын гудамж 15 хаягт байрлах Бэст вестерн премьер туушин зочид буудлын Соёмбо танхимд

Хурал болох өдөр, цаг: 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 09:00 цагт

Хурал болох хэлбэр: Хосолсон /Танхим болон цахимаар/

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2023 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн үндэслэлтэй танилцах;
3. Компанийн 2023 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж, батлах;
4. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох;
5. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэж, батлах;
6. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмын төсөлтэй танилцах;
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн талаар авах зарим арга хэмжээний талаар хэлэлцэж, шийдвэрлэх.


Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт:

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хөтөлбөр;
3. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан;
4. Компанийн 2022 оны аудитлагдсан санхүүгийн тайлан;
5. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт;
6. Компанийн 2023 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний санал;
7. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай танилцуулга;
8. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн шинэчилсэн найруулгын төсөл;

9. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмын төсөл;
10. Ногдол ашиг хуваарилах эсэх талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол;
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудас;
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийн төсөл.

Хувьцаа эзэмшигч Та 2023 оны 3 дугаар сарын 27–ны өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд 09:00 - 17:00 цагийн хооронд өөрт тохиромжтой дараах газруудын аль нэгт эсхүл www.mse.mn/ цахим хуудсаар дамжуулан хурлын материалтай танилцах боломжтой.

- Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани
- "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн байр Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Д.Сүхбаатарын талбай-3
- Хурал зохион байгуулах комиссын утас: 11-313747, цахим шуудан shareholders@mse.mn/
- Хуралд оролцох боломжгүй хувьцаа эзэмшигч Та урьдчилан санал өгөх боломжтой бөгөөд саналын хуудсыг бөглөн өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компаниар дамжуулан эсвэл Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Д.Сүхбаатарын талбай-3 "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн байранд ирж, эсхүл цахим хэлбэрээр "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн цахим хуудас www.mse.mn/-аар өгөх ба саналын хуудсыг авах сүүлийн хугацаа 2023 оны 4 дүгээр сарын 27–ны өдрийн 15:00 цаг байна.



MONGOLIAN
STOCK EXCHANGE



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь заалт, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Дүрмийн 7.3.5 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам", Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 09:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Ерөнхий сайд А.Амарын гудамж 15 хаягт байрлах Бэст вестерн премьер туушин зочид буудлын Соёмбо танхимд хосолсон /танхим болон зайнаас/ хэлбэрээр хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2023 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-нд тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Мөнхзул/-д даалгасугай.

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн цахим хуудсаар болон өдөр тутмын хоёроос доошгүй сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2023 оны 3 дугаар сарын 22-ны өдөр олон нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2023 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр анх гаргасан хэлбэрээр дахин нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /Х.Амарай/-д даалгасугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 4 дүгээр сарын 07-ны өдрөөр тогтоосугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гаргах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралтай холбогдох бусад баримт бичгийг 2023 оны 3 дугаар сарын 27-ны

1523010008

өдөрт багтаан үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д даалгасугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг 1 дүгээр хавсралт, хурлын зарын загварыг 2 дугаар хавсралт, хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг 3 дугаар хавсралт, хурлын саналын хуудасны загварыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссыг 5 дугаар хавсралт, хурлын тооллогын комиссыг 6 дугаар хавсралтад заасан бүрэлдэхүүнтэйгээр тус тус байгуулсугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалтай танилцах боломжийг хувьцаа эзэмшигч бүрд олгох нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д даалгасугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн саналыг урьдчилсан байдлаар 2023 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 15:00 цаг хүртэл хугацаанд брокер дилерийн компаниар дамжуулан эсхүл Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Д.Сүхбаатарын талбай 3 хаягт байрлах "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн байранд цаасан болон цахим хэлбэрээр /www.mse.mn/ урьдчилан авах боломжийг бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комисс /Х.Алтай/-т даалгасугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсыг цаасан болон цахим хэлбэрээр авч, нэгдсэн тооллогын үр дүнг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Тооллогын комисс /А.Мөнхбаясгалан/-т даалгасугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Сангийн дэд сайд /С.Мөнгөнчимэг/-ыг томилсугай.

12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад журамд заасан хугацаанд "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Мөнхзул/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



С.ТУЛГА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 03 сарын 17 өдрийн 15 дугаар
тогтоолын 6 дугаар хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИСС

Комиссын дарга:	Хяналт, зохицуулалтын газрын захирал А.Мөнхбаясгалан
Комиссын гишүүд:	Бүртгэлийн албаны ахлах мэргэжилтэн Д.Нямдорж Бүртгэлийн албаны ахлах мэргэжилтэн М.Энхтуяа Хяналт, шинжилгээний албаны ахлах мэргэжилтэн Д.Баттулга
Комиссын нарийн бичгийн дарга:	Хуульч Ө.Бэрцэцэг


–000–

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР

Хугацаа	Хөтөлбөр	Хариуцагч
09:00-10:00	Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийг бүртгэх	Хурал зохион байгуулах комисс
10:00-10:05	Тооллогын комисс хурлын ирцийг танилцуулах	Тооллогын комисс
10:05-10:15	Хурлын үйл ажиллагааг нээж, дэгийг танилцуулах	Хурлын дарга
10:15-10:20	Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр хэрхэн санал өгөх талаарх дэлгэрэнгүй танилцуулах /Урьдчилсан санал өгсөн хувьцаа эзэмшигч давхардуулж санал өгөхгүй байх/	Тооллогын комисс
10:20-10:35	"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн талаар товч танилцуулах	Гүйцэтгэх захирал Х.Алтай
10:35-10:45	Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга С.Тулга
10:45-11:00	Асуулт, хариулт	
11:00-11:10	Ногдол ашиг хуваарилах эсэх талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн үндэслэлийг тайлагнах	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга С.Тулга
11:10-11:25	Асуулт, хариулт	
11:25-11:35	Компанийн 2023 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж, батлах	Гүйцэтгэх захирал Х.Алтай
11:35-11:50	Асуулт, хариулт	
11:50-11:55	"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох	Гүйцэтгэх захирал Х.Алтай
11:55-12:05	Асуулт, хариулт	
12:05-12:35	Завсарлага	Хурал зохион байгуулах комисс
12:35-12:50	"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэж, батлах	Гүйцэтгэх захирал Х.Алтай
12:50-13:05	Асуулт, хариулт	

13:05-13:15	"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмын төслийг танилцуулах	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга С.Тулга
13:15-13:30	Асуулт, хариулт	
13:30-13:45	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн талаар авах зарим арга хэмжээний талаар хэлэлцэж, шийдвэрлэх	Хурлын дарга
13:45-14:00	Асуулт, хариулт	
14:00-14:35	Завсарлага /Санал хураалт, санал тоолох/	Тооллогын комисс
14:35-14:45	Санал хураалтын дүнг нэгтгэн, танилцуулах	Тооллогын комисс
14:45-15:00	Хурлаас гаргасан шийдвэрийг танилцуулж, хурлыг хаах	Хурлын дарга

Хурлын нийт үргэлжлэх хугацаа: 6 цаг



MONGOLIAN
STOCK EXCHANGE

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржийн холбогдох журам, заавар, компанийн дүрэм болон энэхүү дэгийг баримтлан зохион байгуулна.

Хоёр. Хурлын дарга, түүний эрх үүрэг

2.1. Хурлын дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр эсхүл хурлын даргыг томилсон шийдвэрт заасан этгээд байна.

2.2. Хурлын дарга дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

2.2.1. Хурлын дарга нь хурлыг дэгийн дагуу удирдан явуулж, хуралд оролцогчдоос хурлын дэгийг сахин биелүүлэхийг шаардах;

2.2.2. Хуралд оролцогчдод асуулт асуух зөвшөөрөл олгож, асуулт асуух хугацааг чанд мөрдүүлэх;

2.2.3. Хуралдааны дэг зөрчсөн этгээдэд энэхүү дэгийн 7-д заасан хариуцлага тооцох.

Гурав. Хуралдаанд оролцох

3.1. Хуралд оролцогч нь хурал эхлэхээс 30 минутын өмнө бэлтгэлээ хангаж, бүртгэлээ баталгаажуулсан байна.

3.2. Хуралд оролцогч хувьцаа эзэмшигч иргэн нь танхимаар хуралд оролцохоор ирэхдээ өөрийн хүчин төгөлдөр иргэний үнэмлэхтэй ирнэ. Хэрэв итгэмжлэлийн үндсэн дээр өөрийн төлөөний хүнийг оролцуулах тохиолдолд хүчин төгөлдөр итгэмжлэлийг авч ирнэ.

3.3. Хуралд оролцогч хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага нь танхимаар хуралд оролцохоор ирэхдээ өөрийн компанийн хүчин төгөлдөр гэрчилгээ /эх хувь, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хувилбар/-тэй ирнэ. Хэрэв итгэмжлэлийн үндсэн дээр өөрийн төлөөний хүнийг оролцуулах тохиолдолд хүчин төгөлдөр итгэмжлэлийг авч ирнэ.

3.4. Хуралд оролцогч хувьцаа эзэмшигч иргэн нь цахим хэлбэрээр хуралд оролцохдоо өөрийн хүчин төгөлдөр иргэний үнэмлэхийн хуулбарыг системд оруулна. Хэрэв итгэмжлэлийн үндсэн дээр өөрийн төлөөний хүнийг оролцуулах тохиолдолд хүчин төгөлдөр итгэмжлэлийг системд оруулна.

- 3.5. Хуралд оролцогч хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага нь цахим хэлбэрээр хуралд оролцохоор ирэхдээ өөрийн компанийн хүчин төгөлдөр гэрчилгээ /эх хувь, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хувилбар/-г системд оруулна. Хэрэв итгэмжлэлийн үндсэн дээр өөрийн төлөөний хүнийг оролцуулах тохиолдолд хүчин төгөлдөр итгэмжлэлийг гэрчилгээний хамт системд оруулна.
- 3.6. Хуралд оролцогчийг дараах тохиолдолд хуралд оролцуулахгүй, хурлын танхимаас гаргана. Үүнд:
 - 3.6.1. Хувьцаа эзэмшигч биш байх;
 - 3.6.2. Хувьцаа эзэмшигчийн хуралд оролцох эрхтэйг гэрчлэх бичиг баримтгүй байх;
 - 3.6.3. Хүчин төгөлдөр бичиг баримтын шаардлага хангаагүй байх;
 - 3.6.4. Хурлын үеэр эмх, замбараагүй байдал бий болгох;
 - 3.6.5. Хурлын даргын сануулгыг удаа дараа зөрчих;
 - 3.6.6. Ёс бус үг хэллэг хэрэглэх.
- 3.7. Тооллогын комисс нь энэхүү дэгийн 3.6.-д заасан үндэслэлээр тухайн этгээдийг хуралд оруулахгүй, хурлын танхимаас гаргана.

Дөрөв. Асуулт, хариулт

- 4.1. Хуралд оролцогч нь хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт асууна.
- 4.2. Хурлын дарга нь хэлэлцэх асуудлыг танилцуулсны дараа хуралд оролцогчдоос асуулт байгаа эсэхийг асууна.
- 4.3. Хурал зохион байгуулагч нь асуулт асуух хувьцаа эзэмшигчдийг дараалалд оруулан овог, нэр, асуултыг цаасан дээр тэмдэглэж авна.
- 4.4. Асуултад хариулах этгээд нь хэлэлцэх асуулттай холбоогүй асуултад хариулахаас татгалзах эрхтэй.
- 4.5. Асуултад компанийн эрх бүхий албан тушаалтан хариулна.
- 4.6. Асуулт асуух хугацаа нэг (1) минут байна.
- 4.7. Асуулт асуух хугацаа хэтэрсэн тохиолдолд хурлын дарга хугацаа дууссаныг сануулах бөгөөд сануулснаас хойш 30 секунд өнгөрмөгц хурлын дарга тухайн хүнийг асуултаа дуусгахыг шаардана.

- 4.8. Асуултад хариулж дууссаны дараа хурал зохион байгуулах комисс асуултуудыг цаасан болон цахим хэлбэрээр цуглуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад хүлээлгэн өгнө.

Тав. Хэлэлцэх асуудалтай холбоотой санал өгөх

- 5.1. Урьдчилсан санал гэдэг нь хувьцаа эзэмшигчийн хурлын товлосон өдрөөс өмнө батлагдсан саналын хуудсаар болон цахим хэлбэрээр өгсөн хувьцаа эзэмшигчийн санал байна.
- 5.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах албан ёсны зард тусгагдсан бүртгэлийн өдрөөс эхлэн урьдчилсан санал өгч болно.
- 5.3. Урьдчилсан санал өгсөн тохиолдолд түүнийг дахин өөрчлөхгүй ба тус санал нь эцсийнх байна.
- 5.4. Хуралд оролцогч нь цахим болон цаасан хэлбэрээр өөр агуулгатай санал өгсөн тохиолдолд цаг хугацааны дарааллаар түрүүлж өгсөн саналыг хүчинтэйд тооцно.
- 5.5. Хуралд оролцогч нь хэлэлцэх асуудалтай холбоотойгоор нэг санал өгөх эрхтэй.
- 5.6. Хуралд оролцогч хурлын өмнө санал өгөх заавартай танилцсан байх бөгөөд тус заавар, маягтын дагуу саналаа өгөөгүй бол тухайн саналыг хүчингүйд тооцно.
- 5.7. Хэлэлцэх асуудлын баримт бичгийн төсөл болон тогтоолын төсөлд санал өгөхдөө саналын хуудасны арын хэсэгт бичнэ.
- 5.8. Хуралд оролцогчоос баримт бичгийн төсөл болон тогтоолын төсөлд өгсөн саналыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь саналын товъёгт тусгана. Саналын товъёгт тусгахдаа тухайн хуралд оролцогчийн овог, нэр, оруулах саналыг үнэн зөв, бүрэн гүйцэт тусгана.

Зургаа. Санал тоолох, саналыг нэгтгэн танилцуулах

- 6.1. Саналыг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолд тусгагдсан тооллогын комисс тоолж, нэгтгэнэ.
- 6.2. Тооллогын комиссын дарга нь саналыг нэгтгэж хурлын даргад танилцуулна.
- 6.3. Хуралд оролцогч нь цахим болон цаасан хэлбэрээр давхар санал өгсөн тохиолдолд цаг хугацааны дарааллаар түрүүлж сүүлийн саналыг хүчинтэйд тооцно.
- 6.4. Урьдчилсан байдлаар саналаа өгсөн хувьцаа эзэмшигчийг тус хуралд оролцсонд тооцож бүртгэнэ.

- 6.5. Тооллогын комисс нь цаасан хэлбэрээр өгсөн хүчин төгөлдөр саналыг цахим систем рүү оруулж, саналыг нэгтгэнэ.
- 6.6. Нийт саналыг нэгтгэсэн цахим системийн тайлан болон цаасан хэлбэрээр өгсөн санал /хүчин төгөлдөр болон хүчин төгөлдөр бус/-ыг хамтад нь Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад хүлээлгэн өгч, бусад хурлын материалын хамт компанийн архивд хадгалуулна.

Долоо. Хариуцлага

- 7.1. Хуралдааны дэг зөрчигчид хуралдаан даргалагч эхний удаа сануулна.
- 7.2. Удаа дараа зөрчвөл хурлын танхимаас гаргана.

~000~



MONGOLIAN
STOCK EXCHANGE

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 03 сарын 17 өдрийн 05 дугаар
тогтоолын 1 дүгээр хэвсрэлт

**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ**

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн үндэслэлтэй танилцах;
3. Компанийн 2023 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж, батлах;
4. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох;
5. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэж, батлах;
6. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмын төсөлтэй танилцах;
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн талаар авах зарим арга хэмжээний талаар хэлэлцэж, шийдвэрлэх.

~060~

STOCK EXCHANGE
КОМПАНИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны үйл ажиллагааны
тайланг дүгнэх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 7.3.13 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн 2022 оны үйл ажиллагааны тайланг "Хангалттай" гэж дүгнэсүгэй.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг "91 хувь" гэж дүгнэн, цаашид Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, тайлагнаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д даалгасугай.

3. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан талаарх тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг компанийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /А.Анар/-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



С.ТУЛГА

1523010011

STOCK EXCHANGE

КОМПАНИЙН 2022 ОНЫ АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны санхүүгийн тайланд өгөх дүгнэлтийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 7.3.13 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүлээн авч, санхүүгийн үйл ажиллагааг "Сайжруулах шаардлагатай" гэж дүгнэн, цаашид санхүүгийн үйл ажиллагааг зохих хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн дүрэм журамд нийцүүлж, санхүүгийн тайлагналыг чанартай хийж гүйцэтгэх, мэргэжлийн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д даалгасугай.

2. Хараат бус аудиторын өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, хэрэгжилтийг тогтоосон хугацаанд тайлагнаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д даалгасугай.

3. Компанийн 2022 оны санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг компанийн 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /А.Анар/-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



С.ТУЛГА

1523010014

STOCK EXCHANGE

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ЭСЭХ ТАЛААР ГАРГАСАН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭР

КОМПАНИЙН 2023 ОНЫ ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ,



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Ногдол ашгийн талаар

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.6, 47 дугаар зүйлийн 47.1.2, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Дүрмийн 4.1, 7.3.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 29 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Ногдол ашгийн бодлого"-ын 2.2.3, 2.2.5 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн тухай хууль болон "Ногдол ашгийн бодлого"-д заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл хангагдахгүй байх тул компанийн 2022 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
2. Ногдол ашиг хуваарилаагүй талаарх үндэслэлийг Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ээлжит хуралд тайлагнасугай.
3. Энэхүү тогтоолыг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Мөнхзул/-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /А.Анар/-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



С.ТУЛГА

1523010076

ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ САНАЛ



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21¹ дүгээр зүйл, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Дүрмийн 7.3.1, 7.3.2, 7.3.3, 7.3.4 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2023 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг 1 дүгээр хавсралтаар дэмжсүгэй.
2. Компанийн 2023 оны Бизнес төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар баталсугай.
3. Компанийн 2023 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний санал, 2023 оны Бизнес төлөвлөгөөг хувьцаа эзэмшигчид болон зохих байгууллагад хүргүүлэх, баталгаажуулах ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /А.Анар/-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



С.ТУЛГА

1523010018

STOCK EXCHANGE



**"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК-ИЙН 2023 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ САНАЛ**

д/д	Үзүүлэлтүүд	2022 оны		2021 оны гүйцэтгэл*	2023 оны Төлөвлөгөө		2022 оны Гүйцэтгэл		2023 оны Төлөвлөгөө	2022 оны гүйцэтгэлтэй харьцуулсан өөрчлөлт	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Хувь	Мөнгөн дүн	Хувь	Мөнгөн дүн			
										Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Үйл ажиллагааны нийт орлого:	6,033,833	4,268,416	5,520,984	9,429,465	121%	5,161,049				
1.1	Үндэт цаасны арилжааны орлого	3,595,374	2,031,112	3,548,107	4,112,424	102%	2,081,312				
1.2	Нүүрсний арилжааны орлого				2,198,663	шинэ	2,198,663				
1.3	Жилийн хуртамж, үйл шилжлийн хөлс	2,049,083	1,869,696	1,181,472	2,365,350	27%	495,655				
1.4	МТ ашиглалтын орлоо	-	6,364	509,974		-100%	(6,364)				
1.5	Бусад	389,376	361,244	281,430	753,007	108%	391,763				
2	Үйл ажиллагааны нийт зардал:	4,354,385	3,629,535	2,168,807	6,576,298	81%	2,946,763				
2.1	Үйл ажиллагааны зардал	3,013,002	2,011,822	990,606	3,875,825	93%	1,864,003				
2.2	ҮХ эзгээдлийн зардал	497,192	396,509	239,905	928,994	134%	532,485				
2.3	МТ ашиглалтын зардал	844,191	1,221,204	938,295	1,771,479	45%	550,275				
3	Үйл ажиллагааны татварын өмнөх цэвэр орлого /алдагдал/	1,679,448	769,748	3,352,177	2,853,167	271%	2,083,419				
4	Орлогын татвар		123,520		189,525						
5	Татварын дараах цэвэр ашиг /алдагдал/	1,511,504	646,228	3,183,991	2,663,642	312%	2,017,414				
6	Нийт авлага /цэвэр/	56,906	504,659	97,241	51,460	-90%	(453,199)				
7	Нийт өглөг /МТ зардал оруулж тооцсоноор/	772,900	979,471	926,821	218,319	-78%	(761,152)				
8	Ногдол ашиг хуваари талт										
9	Ажиллагсдын тоо	55	53	53	69	30%	16				
10	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох үйл ажиллагааны зардал	0.72	0.85	0.39	0.70	-18%	(0.15)				
11	Хөрөнгө оруулалт	1,057,830	557,807	166,540	5,700,348	922%	5,142,541				

(мянган төгрөг)

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

"Монголын хөрөнгийн бирж" ХК /МХБ/ нь нэмэлт хувьцаагаа биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгон худалдах үйл ажиллагааг 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хооронд амжилттай зохион байгуулсан.

Уг хувьцааг анхдагч зах зээлд санал болгон худалдах үйл ажиллагааны үр дүнд 119,157,603 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 100 төгрөгөөр санал болгож 11,915,760,300 /арван нэгэн тэрбум есөн зуун арван таван сая долоон зуун жаран мянга гурван зуу/ төгрөгийг олон нийтээс татан төвлөрүүлсэн. Компанийн хувьцаа эзэмшлийн бүтцийг дараах хүснэгтээр харуулав. Үүнд:

/Хувьцааны эзэмшлийн тоо, хэмжээ/

№	Хувьцаа эзэмшигч	Хувьцаа гаргахаас өмнө			Хувьцаа гаргасны дараа		
		Эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, төг	Эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг	Эзэмшлийн хувь	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, төг
1	Төр	231,305,936	100%	23,130,593,600	231,305,936	66%	23,130,593,600
2	Олон нийт	-	-	-	119,157,603	34%	11,915,760,300
	Нийт	231,305,936	100%	231,305,936	350,463,539	100%	35,046,353,900

Хувьцааг олон нийтэд санал болгож олон нийтээс татан төвлөрүүлсэн 11,915,760,300 /арван нэгэн тэрбум есөн зуун арван таван сая долоон зуун жаран мянга гурван зуу/ төгрөгийг МХБ-ийн өөрийн хөрөнгөд бүртгэхдээ хувь нийлүүлсэн хөрөнгө хэсэгт нэгж хувьцааны нэрлэсэн үнэ болох 100 төгрөгөөр тооцож 11,915,760,300 /арван нэгэн тэрбум есөн зуун арван таван сая долоон зуун жаран мянга гурван зуу/ төгрөгөөр нэмэгдүүлэн бүртгэхээр байна.

Иймд МХБ-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 35,046,353,900 /Гучин таван тэрбум дөчин зургаан сая гурван зуун наян тавин гурван мянга есөн зуу/ төгрөгөөр тогтоон МХБ-ийн дүрэмд тусгаж, эрх бүхий байгууллагад бүртгүүлэх шаардлагатай тул Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх саналтай байна.

MONGOLIAN
STOCK EXCHANGE

ТӨСӨЛ

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2023 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар
тогтоолын хавсралт

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Дүрмийн зорилго, компанийн эрх зүйн байдал

- 1.1. Энэхүү дүрмийн зорилт нь “Монголын хөрөнгийн бирж” нээлттэй хувьцаат компани /цаашид “Компани” эсхүл “Бирж” гэх/-ийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлага, хяналтын бүтэц, тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлоход оршино.
- 1.2. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, бие даасан тайлан тэнцэл гаргадаг, банканд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдэлж, үүрэг хүлээдэг, тусгайлсан хөрөнгөтэй, ашгийн төлөө хуулийн этгээд мөн. Компани өөрийн бэлгэдэл, барааны тэмдэгтэй байж болох бөгөөд түүний загварыг Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/ баталж, Оюуны өмчийн газар бүртгүүлнэ.
- 1.3. Компани нь өөрийн албан бичгийн хэвлэмэл хуудас, оноосон нэр бүхий тэмдэгтэй байна.
- 1.4. Компани нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.
- 1.5. Компани үйл ажиллагаандаа нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, компанийн засаглалын шилдэг жишгийг удирдлага болгоно.
- 1.6. Энэхүү дүрмийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид үндэслэн боловсруулсан бөгөөд хожим хууль, тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлт нь дүрмийн хэсэг, зүйл, заалттай зөрчилдөх тохиолдолд хуулийн зохицуулалтыг мөрдөх бөгөөд шаардлагатай тохиолдолд дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 1.7. Компанийн дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлтийг хууль тогтоомжид заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.
- 1.8. Компани нь төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани бөгөөд төрийн өмчийн төлөөлөл буюу хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь Засгийн газраас эрх олгосны дагуу Сангийн яам байна¹.
- 1.9. Компани Монгол Улс болон гадаадад өөрийн салбар, төлөөлөгчийн газартай байж болно. Салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрхгүй болно.

Оноосон нэр, хаяг

- 1.10. Компанийн оноосон нэрийг Монгол хэлээр “Монголын хөрөнгийн бирж” ХК, Англи хэлээр “Mongolian Stock Exchange” JSC , товчоор “MSE” JSC гэнэ. Компани нь хуулийн

¹ Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 152 дугаар тогтоол

этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд оноосон нэрийнхээ дараа “ХК” гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ.

- 1.11. Компанийн төв байрны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Сүхбаатарын талбай 3 болно.

Утас, Факс: 11-310506

Цахим шуудан: info@mse.mn

Цахим хаяг: www.mse.mn

ХОЁРДУГААР БҮЛЭГ. КОМПАНИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ХУГАЦАА

- 2.1. Компанийн эрхэм зорилго нь үндэсний үйлдвэрлэл үйлчилгээг сэргээн хөгжүүлэх, дотоод гадаадын хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, дэмжин урамшуулахад үйл ажиллагаагаа чиглүүлж, үнэт цаасны зах зээлийг сонгодог утгаар нь төлөвшүүлэн хөгжүүлэхэд оршино.
- 2.2. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь үнэт цаасны зах зээлд үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа болон өөрийгөө зохицуулах байгууллагын үйл ажиллагаа байна.
- 2.3. Монголын хөрөнгийн бирж нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан зохицуулалттай этгээд болох арилжаа эрхлэх болон өөрийгөө зохицуулах байгууллагын хувьд хуульд заасан дүрэм, журмуудыг баталж мөрдүүлэх, арилжаа зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 2.4. Компани нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа явуулах тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч улсын бүртгэлд бүртгүүлсний үндсэн дээр тухайн үйл ажиллагааг эрхэлнэ.
- 2.5. Компани нь үйл ажиллагаагаа хугацаагүйгээр явуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

Хувь нийлүүлсэн хөрөнгө

- 3.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь компанийн нийт гаргасан эргэлтэд байгаа хувьцаанаас бүрдэх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгөнд зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй.
- 3.2. Компани нь нэг бүр нь 100 (нэг зуу) төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 350,463,539 (гурван зуун тавин сая дөрвөн зуун жаран гурван мянга таван зуун гучин ес) ширхэг энгийн хувьцаатай буюу нийт 35,046,353,900 (гучин таван тэрбум дөчин зургаан сая гурван зуун тавин гурван мянга есөн зуу) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.
- 3.3. Компанийн хувьцаа эзэмшигчид нь дараах байдлаар компанийн хувьцааг эзэмшинэ:

№	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны			Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн
		Нэрлэсэн үнэ	Тоо ширхэг	Эзэмшлийн хувь	
1	Төр	100 төг	231,305,936	66 хувь	23,130,593,600
2	Олон нийт	100 төг	119,157,603	34 хувь	11,915,760,300
	Нийт	100 төг	350,463,539	100 хувь	35,046,353,900

3.4. Компанийн энгийн хувьцаа нэг бүр нь нэг саналын эрхтэй байна. Хувьцаа нь хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд аливаа эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.

Өөрийн хөрөнгө

3.5. Компанийн балансад тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн дүнгээс компанийн нийт өр төлбөрийг хасаад үлдсэн хэсгийг компанийн өөрийн хөрөнгө гэнэ.

3.6. Тухайн жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд уг нөхцөл байдал бүртгэгдсэн албан ёсны санхүүгийн тайлан гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор ТУЗ Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлаж, хувь нийлүүлсэн хөрөнгөнд өөрчлөлт оруулах, компанийг дахин хөрөнгөжүүлэх, эсхүл татан буулгах асуудлыг шийдвэрлүүлэх үүрэгтэй.

Компанийн хувьцаа эзэмшигч

3.7. Хуулиар хориглоогүй бол хувьцаа эзэмшигчид нь хувь хүн, хуулийн этгээд байна.

3.8. Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг үнэт цаасны хадгаламж, бүртгэлийн эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

Компанийн болон хувьцаа эзэмшигчдийн хариуцлага

3.9. Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ.

3.10. Компани нь Хувьцаа эзэмшигчийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд Хувьцаа эзэмшигч нь Компанийн хүлээх үүргийг хариуцахгүй.

3.11. Компанийн хувьцаа эзэмшигчид нь гагцхүү өөрийн эзэмшиж буй хувьцааныхаа хэмжээгээр эрсдэл, хариуцлага хүлээнэ.

МОНГОЛЫН
STOCK EXCHANGE

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурал, түүнийг зарлан хуралдуулах

- 4.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.
- 4.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит болон ээлжит бус байх бөгөөд ээлжит хурлыг ТУЗ нь Компанийн тухай хуульд заасан хугацаанд буюу санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор жилд нэг удаа зарлан хуралдуулна.
- 4.3. Дараах тохиолдолд ТУЗ хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна:
 - 4.3.1. ТУЗ-ийн нийт гишүүний 50-аас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;
 - 4.3.2. ТУЗ-ийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцааг дангаар эзэмшигч санал, шаардлага гаргасан;
 - 4.3.3. Компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн;
 - 4.3.4. Аудитын хорооноос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийхийг шаардсан;
 - 4.3.5. ТУЗ шаардлагатай гэж үзэж шийдвэр гаргасан;
 - 4.3.6. Компанийн тухай хууль болон дүрэмд заасан бусад тохиолдол.
- 4.4. Хурал хуралдуулах тухай шийдвэрт дараах зүйлийг заана:
 - 4.4.1. Хурал хуралдуулах газар, өдөр, цаг;
 - 4.4.2. Хурлын хэлэлцэх асуудал;
 - 4.4.3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;
 - 4.4.4. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журам;
 - 4.4.5. Хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт;
 - 4.4.6. Саналын хуудсаар санал авах бол тухайн саналын хуудасны агуулга;
 - 4.4.7. Саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр;
 - 4.4.8. Хурлын дарга;
 - 4.4.9. Тооллогын комиссын дарга, гишүүд.
- 4.5. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш 40-өөс доошгүй хоногийн дараа хуралдуулна.
- 4.6. Компани хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш 5 хоногийн дотор хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдээлнэ.
- 4.7. Хурлын зард дараах зүйлийг тусгана:
 - 4.7.1. Компанийн оноосон нэр, байршил;
 - 4.7.2. Хурал хийх өдөр, цаг, газар;
 - 4.7.3. Бүртгэлийн өдөр;
 - 4.7.4. Хурлаар хэлэлцэх асуудал, шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх

- 4.8. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх бүрэн эрхтэй. Үүнд:
- 4.8.1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
 - 4.8.2. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
 - 4.8.3. Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;
 - 4.8.4. Компанийн хэлбэрийг өөрчлөх;
 - 4.8.5. Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
 - 4.8.6. Хувьцааг хуваах буюу нэгтгэх;
 - 4.8.7. ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
 - 4.8.8. Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигч нь хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэх;
 - 4.8.9. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлд заасны дагуу гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - 4.8.10. ТУЗ-өөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Компанийн тухай хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг батлах;
 - 4.8.11. ТУЗ-өөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
 - 4.8.12. Хуульд заасны дагуу компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх;
 - 4.8.13. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
 - 4.8.14. ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;
 - 4.8.15. Хувьцаагаа үнэт цаасны хадгаламжийн байгууллагын бүртгэлээс хасуулах асуудал;
 - 4.8.16. Хууль тогтоомжид заасан бусад.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох

- 4.9. Дараах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор батална. Үүнд:
- 4.9.1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг батлах;
 - 4.9.2. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
 - 4.9.3. Компанийн хэлбэрийг өөрчлөх;
 - 4.9.4. Компанийн өрийг хувьцаагаар солих, нэмж хувьцаа гаргах, түүний тоог тогтоох;

- 4.9.5. Давуу эрхийн хувьцаа гаргах;
 - 4.9.6. Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
 - 4.9.7. Хувьцааг хуваах буюу нэгтгэх;
 - 4.9.8. Хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх;
 - 4.9.9. Энэхүү дүрмийн долоодугаар бүлэгт заасан Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг батлах, хяналтын зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, чөлөөлөх, Хяналтын зөвлөлийн гишүүний цалинг тогтоох;
 - 4.9.10. Хяналтын зөвлөлийн жилийн үйл ажиллагааны тайлантай танилцах, хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар Хяналтын зөвлөлөөс ирүүлсэн санал, хүсэлтийг зохих журмын дагуу шийдвэрлэх;
 - 4.9.11. Хууль болон энэхүү дүрэмд заасан бусад асуудал.
- 4.10. Энэхүү дүрмийн 4.9-д заасан болон ТУЗ-ийн гишүүдийг сонгохоос бусад асуудлаар гаргах шийдвэр нь хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын олонх дэмжсэнээр хүчин төгөлдөр болно.
 - 4.11. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ. Энэ аргыг хэрэглэхдээ Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмыг баримтална.
 - 4.12. Хувьцаа эзэмшигч нь ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй хүнд тус тусад нь саналаа өгнө. Энэ тухай зааврыг Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны журмыг баримтлан тухайн хурлын санал авах хуудсанд тусгана.
 - 4.13. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгох саналыг тоолохдоо тус бүрд нь тоолж, хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр тус тус сонгоно.
- Хуралд оролцох журам**
- 4.14. Хувьцаа эзэмшигч нь иргэний үнэмлэхтэйгээ ирж, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаас бүртгэлийн өдрөөр тодорхойлсон хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган бүртгүүлж хуралд оролцоно. Хэрэв хуралд биеэр оролцох боломжгүй бол өөрийгөө төлөөлүүлж хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох этгээдэд нотариатаар гэрчлүүлсэн итгэмжлэлийн үндсэн дээр оролцуулж болно.
 - 4.15. Төлөөлөх тухай итгэмжлэл нь тодорхой хугацаа заагаагүй бол гагцхүү тухайн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүчинтэй. Хувьцаа эзэмшигчдийн хурал хойшилсон боловч тухайн хурлаар хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл хойшлогдсон хуралд хүчинтэй хэвээр байна.
 - 4.16. Хувьцаа эзэмшигчдийн хуралд ирүүлсэн саналын хуудас, мөн хувьцаа эзэмшигчийн итгэмжлэлийг хурлыг зарласан өдрөөс эхлэн хурал хуралдах өдрийн хурал эхлэх цаг хүртэл хүлээн авч бүртгэнэ. Хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг энэхүү дүрэмд зааснаар тогтоосон бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тодорхойлж, тооллогын комисс, эсхүл түүний үүргийг гүйцэтгэхээр ТУЗ-өөс тусгайлан томилсон этгээд гүйцэтгэнэ.
 - 4.17. Хувьцаа эзэмшигчид нь хэлэлцэж буй асуудлын талаар саналаа санал авах хуудсаар ирүүлсэн тохиолдолд түүнийг тухайн хуралд оролцсонд тооцно. Хурлын ирцийг

хэлэлцэх асуудал бүрээр гаргах бөгөөд тухайн хэлэлцэх асуудалд санал ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг тухайн асуудал хэлэлцэхэд оролцсонд тооцно. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулахыг хориглоно.

Хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болох

- 4.18. Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.
- 4.19. Хурлын ирц хүрээгүй тохиолдолд хурлыг хойшлуулах бөгөөд харин хэлэлцэх асуудал хэвээр байна. Хойшлогдсон хурлыг ажлын 20 өдрийн дотор хуралдуулах бөгөөд уг хурал хуралдахаас ажлын долоогоос доошгүй өдрийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ.
- 4.20. Саналын эрхийн 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцоноор хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болно.
- 4.21. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах, нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах, компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох, компанийн хэлбэрийг өөрчлөх, компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох, хувьцааг хуваах буюу нэгтгэх тухай асуудлыг хэлэлцэх хойшлогдсон хурал нь саналын эрхийн гуравны нэгээс доошгүй хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцоноор хүчин төгөлдөр болно.

Бүртгэлийн өдөр

- 4.22. Компанийн бүртгэлийн өдрийг ТУЗ хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргах үед тогтоох бөгөөд энэ өдөр нь хурал хуралдуулах тухай шийдвэр гарсан өдрөөс өмнө байж болохгүй.

Санал авах хуудас, түүнийг хүчинтэйд тооцох

- 4.23. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлаар саналыг санал авах хуудсаар авч болно. Энэ тухай ТУЗ хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрт заана.
- 4.24. Санал авах хуудасны агуулгыг ТУЗ хурал хуралдуулах тухай шийдвэрт тусгана. Санал авах хуудсанд Компанийн оноосон нэр, хурал хийх газар, өдөр, цаг, хувьцаа эзэмшигчдийн нэр, эзэмшиж буй хувьцааны төрөл, тоо хэмжээ, санал хураалтаар шийдвэрлэх асуудлын нэр, хурлаас хэлэлцэх асуудал бүрээр гарах шийдвэрийн төсөл зэргийг тусгана.
- 4.25. Санал авах хуудсанд (ТУЗ болон Хяналтын зөвлөлийн гишүүнийг сонгохоос бусад тохиолдолд) санал өгөх хувилбарын зөвхөн нэгийг тэмдэглэсэн тохиолдолд хүчинтэй байна. Санал авах хуудсыг хурал зарласан өдрөөс эхлэн тухайн асуудлыг хэлэлцэж дуусах хүртэлх хугацаанд авна.

Цахим хэлбэрээр санал авах

- 4.26. Компани цахимаар санал авах цахим программыг хөгжүүлж, ашиглах талаар зохих туршлага бүхий мэдээллийн технологийн компанитай үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж, санал хураалтыг цахим хэлбэрээр явуулж болно. Энэ тохиолдолд хуралд оролцогчийг системд бүртгэх, түүний саналыг авах, ирцийн мэдээ болон авсан саналын дүнг өөрчлөх боломжгүйгээр, үнэн зөв илэрхийлэх боломжтой программыг бүтээх үүргийг мэдээллийн технологийн компани хүлээнэ. Түүнчлэн мэдээллийн технологийн компани нь энэхүү үүргээ баталгаажуулсан албан бичгийг компанид хүлээлгэж өгнө.

Хурлын зардал, хурлын тэмдэглэл

- 4.27. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбогдох зардлыг компани бүрэн хариуцна.
- 4.28. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэр гарах бөгөөд хурал дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор хурлын тэмдэглэлийг албажуулж, хурлын дарга гарын үсэг зурах бөгөөд хурлын дарга тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцна.
- 4.29. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлд тусгах мэдээлэл, санал хураалтын дүнг зарлах болон тэмдэглэлтэй холбоотой бусад харилцааг Компанийн тухай хуульд зааснаар зохицуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

- 5.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна.
- 5.2. ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага, чиг үүрэг, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх, үүрэг зэргийг Компанийн тухай хуульд нийцүүлэн “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-аар тогтоох бөгөөд уг журмыг ТУЗ батлан мөрдүүлнэ.
- 5.3. Компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 1/3 (гуравны нэг)-ээс доошгүй нь хараат бус гишүүн байна.
- 5.4. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 1 (нэг) жил байна. ТУЗ-ийн гишүүнийг хэдэн ч удаа улируулан сонгож болно.
- 5.5. ТУЗ-ийн гишүүнд урамшуулал олгож болох бөгөөд ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтооно. Урамшуулалтай холбоотой бусад харилцааг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.
- 5.6. Удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл ТУЗ түр томилж болно. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох үндэслэлийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

ТУЗ-ийн бүрэн эрх

- 5.7. ТУЗ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 5.7.1. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, компанийн бизнес төлөвлөгөөг батлах;
- 5.7.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;

- 5.7.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах, бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
 - 5.7.4. Компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;
 - 5.7.5. Компанийн дүрэмд заасан хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах;
 - 5.7.6. Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
 - 5.7.7. Өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах;
 - 5.7.8. Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;
 - 5.7.9. Компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;
 - 5.7.10. Аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;
 - 5.7.11. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;
 - 5.7.12. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;
 - 5.7.13. Компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;
 - 5.7.14. Компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
 - 5.7.15. Хуульд заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
 - 5.7.16. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
 - 5.7.17. Ногдол ашгийн хэмжээг тогтоож, төлөх журмыг батлах;
 - 5.7.18. Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг батлах;
 - 5.7.19. Компанийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тодорхойлох;
 - 5.7.20. Эрх бүхий албан тушаалтны компанид учруулсан хохирлын талаар шүүхэд нэхэмжлэл гаргах;
 - 5.7.21. Арилжаа эрхлэх байгууллагын Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан журмуудыг баталж, нийтэд мэдээлэх;
 - 5.7.22. Өөрийгөө зохицуулах байгууллагын Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан дүрэм, журмуудыг баталж мөрдүүлэх;
 - 5.7.23. Дүрмийн 5.7.22-т заасан дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээг тогтоох;
 - 5.7.24. ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Хяналтын зөвлөлөөс ирүүлсэн санал, хүсэлтийг зохих журмын дагуу шийдвэрлэх;
 - 5.7.25. Хууль болон компанийн дүрэмд заасан, эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал.
- 5.8. ТУЗ нь хууль тогтоомжид зөвхөн ТУЗ хэрэгжүүлэхээр зааснаас бусад бүрэн эрхээ Гүйцэтгэх удирдлагад хариуцуулан гүйцэтгүүлж болно.

ТУЗ-ийн хурал

- 5.9. ТУЗ-ийн хурлыг улиралд нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн дарга, компанийн Гүйцэтгэх захирлын санаачилгаар, эсхүл ТУЗ-ийн дэргэдэх хорооны саналаар ээлжит бус хурал хуралдуулж болно.
- 5.10. ТУЗ-ийн хуралд аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүн бүр саналын нэг эрхтэй байна.
- 5.11. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хурал хүчин төгөлдөр болж, хуульд өөрөөр заагаагүй бол хуралд оролцсон саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхын саналаар хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно.
- 5.12. ТУЗ эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.
- 5.13. ТУЗ-ийн хурлаас тогтоол гаргах бөгөөд түүнд ТУЗ-ийн хурлын дарга гарын үсэг зурна.
- 5.14. Компанийн ТУЗ нь хувьцаа эзэмшигчдэд зориулан жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан бичиж хүргүүлэх бөгөөд тайланд дараах зүйлийг тусгана:
 - 5.14.1. Тайлангийн хугацаанд компанийн эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга, гарсан өөрчлөлтүүд болон эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн байдал, бүтэц, зохион байгуулалт, түүний өөрчлөлт;
 - 5.14.2. Тайлангийн хугацаанд компанийн эрх бүхий албан тушаалтанд олгосон шагнал урамшуулал удирдлагын зардлын хэмжээ;
 - 5.14.3. Хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл.

ТУЗ-ийн хурлын тэмдэглэл

- 5.15. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд дараах зүйлийг тусгана:
 - 5.15.1. Хурал хуралдсан газар, өдөр, цаг;
 - 5.15.2. Хуралд оролцсон гишүүд;
 - 5.15.3. Хурлаар хэлэлцсэн асуудал;
 - 5.15.4. Санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал болон санал хураалтын дүн;
 - 5.15.5. Гаргасан шийдвэр.
- 5.16. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүд гарын үсэг зурах бөгөөд тухайн тэмдэглэлийн үнэн зөвийг тухайн хурлын дарга хариуцна.
- 5.17. ТУЗ-ийн аль нэг гишүүн ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзсан бол энэ тухай бичгээр тайлбар гаргана.
- 5.18. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг буруу хөтөлсөн нь тухайн хурлаас гаргасан шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.

ТУЗ-ийн дарга

- 5.19. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн дотроос тэдгээрийн олонхын саналаар сонгоно.
- 5.20. Компанийн ТУЗ-ийн дарга нь бусад гишүүдтэй адил эрх эдлэхээс гадна ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих чиг үүргийг гүйцэтгэнэ.
- 5.21. ТУЗ-ийн даргын түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын томилсон, эсхүл ТУЗ-ийн томилсон аль нэг гишүүн гүйцэтгэнэ.

ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэн сонгох

- 5.22. Компанийн залгамж халааны бодлогын баримт бичгийг ТУЗ батална.
- 5.23. ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хороо нь Компанийн залгамж холбооны бодлогын дагуу ТУЗ-ийн гишүүнд Компанийн тухай хууль болон ТУЗ-ийн зохих журамд заасан шалгуурыг хангасан хүнийг сонгон шалгаруулж нэр дэвшүүлэн ХЭХ-аар хэлэлцүүлнэ.

ТУЗ-ийн хараат бус гишүүн

- 5.24. ТУЗ нь хараат бус гишүүнтэй байна. ТУЗ-ийн хараат бус гишүүнд дараах шалгуурыг хангасан хүний нэрийг ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хороо дэвшүүлнэ:
- 5.24.1. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй;
- 5.24.2. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй;
- 5.24.3. Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй;
- 5.24.4. Компанитай бизнесийн аливаа холбоогүй;
- 5.24.5. Хууль тогтоомжид заасан бусад шаардлага.
- 5.25. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь бусад гишүүдийн адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах нэмэлт үүргийг хүлээнэ:
- 5.25.1. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь тухайн компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцэж буй эсэхэд хяналт тавих, зөрчихөөс урьдчилан сэргийлэх, зөрчсөн тохиолдолд холбогдох этгээдэд тавьж шийдвэрлүүлэх, шаардлагыг эс биелүүлбэл ТУЗ-д тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах шаардлага хүргүүлэх;
- 5.25.2. Компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;
- 5.25.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн оролцож, ТУЗ-ийн зарим шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлэх эрхтэй;
- 5.25.4. Компанийн нөхцөл байдал, ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэрийн талаар хувьцаа эзэмшигчдээс асуусан асуултад хариу өгөх, тодруулга хийх;
- 5.25.5. Компанийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг үр ашигтай зохион байгуулж байгаа эсэхэд хяналт тавих;
- 5.25.6. Компанийн тухай хуульд заасан бусад эрх, үүрэг.
- 5.26. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүд дараах асуудлыг хэлэлцэхэд заавал оролцож саналаа өгнө. Үүнд:
- 5.26.1. Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;

- 5.26.2. Санхүүгийн тайланд аудит хийх хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;
- 5.26.3. Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт тодорхойлсон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

- 5.27. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилно.
- 5.28. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ийн бичиг хэргийг хариуцан хөтлөх, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх зэрэг ТУЗ-ийн журмаар тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 5.29. Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлын бэлтгэлийг хангах бөгөөд хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл болон гарах шийдвэрийн төсөл, бусад баримт бичгийг зохих журмын дагуу бэлтгэх, хүргэх ажлыг зохион байгуулна.
- 5.30. Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг хөтлөх, гарах шийдвэрийг зохих журмын дагуу баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавина.
- 5.31. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах ажлыг зохион байгуулна.
- 5.32. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эзгүйд түүний үүргийг орлох этгээдийг ТУЗ-ийн дарга томилно.
- 5.33. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн дотоод үйл ажиллагааг хариуцан зохицуулна.

ТУЗ-ийн дэргэдэх хороо

- 5.34. ТУЗ нь дэргэдээ нь (а) Аудитын хороо; (б) Эрсдэл /комплайнс/-ийн удирдлагын хороо; в) Нэр дэвшүүлэх; г) Цалин урамшууллын хороо гэсэн байнгын хороодтой байна.
- 5.35. Аудитын, Эрсдэл /комплайнс/-ийн удирдлагын, Нэр дэвшүүлэх, Цалин, урамшууллын хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.
- 5.36. Компанийн ТУЗ нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороо байгуулан ажиллуулж болно.
- 5.37. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна:
 - 5.37.1. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
 - 5.37.2. Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах;
 - 5.37.3. Аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;
 - 5.37.4. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;
 - 5.37.5. Компанийн дүрэмд заасан болон ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

- 5.38. Эрсдэл /комплайнс/-ийн удирдлагын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна:
- 5.38.1. Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого, зохицуулалтын орчныг тодорхойлох;
 - 5.38.2. Компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг оновчтой удирдан чиглүүлэх;
 - 5.38.3. Компанийн үйл ажиллагааны гүйцэтгэл, эрсдэлийн түвшинд хяналт тавих.
- 5.39. Нэр дэвшүүлэх хороо нь дараах чиглэлээр, дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулна:
- 5.39.1. Компанийн залгамж холбооны бодлогыг боловсруулах, үйл ажиллагаандаа чанд мөрдөж, хэрэгжүүлэх;
 - 5.39.2. Компанийн ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;
 - 5.39.3. ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүний хувьд энэ дүрэм болон Компанийн тухай хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
 - 5.39.4. Компанийн залгамж холбооны бодлогын дагуу ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвших боломжтой этгээдийн судалгаа хийх, нөөцөд бүртгэх, бэлтгэх, шаардлагатай бол сонгон шалгаруулалт хийх, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;
 - 5.39.5. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;
 - 5.39.6. Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;
 - 5.39.7. ТУЗ-ийн гишүүнээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;
 - 5.39.8. Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.5-д заасан үндэслэлээр ТУЗ-ийн бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш гурван жилийн хугацаанд тухайн ТУЗ-ийн гишүүн байсан этгээдийн нэрийг аливаа хувьцаат компанийн ТУЗ-ийн гишүүнд дэвшүүлэхээс татгалзах.
- 5.40. Цалин, урамшууллын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна:
- 5.40.1. Компанийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
 - 5.40.2. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;
 - 5.40.3. Компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх.
- 5.41. ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтооно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА, ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

Гүйцэтгэх захирал

- 6.1. Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ажлаа ТУЗ-д тайлагнана.
- 6.2. Компанийн гүйцэтгэх удирдлагыг хувь хүн хэрэгжүүлэх бөгөөд уг этгээд компанийн Гүйцэтгэх захирал байна.
- 6.3. Гүйцэтгэх захирал нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шалгуурыг хангаж холбогдох баримт бичгийг бүрдүүлэхээс гадна дараах шалгуурыг хангасан байна:
 - 6.3.1. Банк, санхүү, эдийн засаг, хууль, эрх зүйн дээд боловсролтой, санхүүгийн салбарт таваас доошгүй жил эрх бүхий албан тушаалтнаар ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай;
 - 6.3.2. Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй;
 - 6.3.3. Төрийн эсрэг болон эдийн засгийн гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй;
 - 6.3.4. Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх;
 - 6.3.5. Хууль тогтоомж, гэрээнд заасан бусад шаардлага.
- 6.4. Компанийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч этгээд нь ТУЗ-ийн гишүүн байж болох бөгөөд ТУЗ-ийн дарга байхыг хориглоно.
- 6.5. Гүйцэтгэх удирдлага нь төрийн болон хувийн өмчийн, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ТУЗ-д орох, тэдгээрийн захиргаанд, төрийн бус байгууллага болон шашны байгууллага, сангийн удирдах ажлыг хавсран гүйцэтгэхийг хориглоно.
- 6.6. Гүйцэтгэх захирал нь ээлжийн амралт эдлэх, гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, чөлөө авах, өвдөх тохиолдолд өөрийн эрх, үүргийг бүхэлд нь Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу эрх бүхий этгээдэд зөвхөн ТУЗ-ийн зөвшөөрлөөр шилжүүлнэ. Түүнчлэн Гүйцэтгэх захирал тодорхой бүрэн эрхээ компанийн холбогдох албан тушаалтан, ажилтанд итгэмжлэн хариуцуулж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 6.7. Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-тэй байгуулсан онцгой нөхцөл бүхий гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна.
- 6.8. Гэрээнд Гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин, шагнал, урамшуулал, хугацаа, гэрээ дүгнэх шалгуур зэрэг асуудлыг тусгасан байна.
- 6.9. Гүйцэтгэх захирал нь дор дурдсан эрх эдэлнэ:
 - 6.9.1. Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажил олгогчийн эрхийг хэрэгжүүлэх;
 - 6.9.2. ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулах;
 - 6.9.3. Эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргаж биелэлтийг нь хангуулах эрхтэй;
 - 6.9.4. Компанийн хөрөнгө захиран зарцуулах төлбөрийн баримтад гарын үсэг зурах;

- 6.9.5. Компанид учруулсан хохирлыг төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах, эрүү, захиргаа, иргэний хэрэгт нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилон оролцуулах;
 - 6.9.6. ТУЗ-өөс баталсан зардлын хэмжээнд багтаан ажилтнуудын орон тоо, үндсэн болон нэмэгдэл цалин, тэтгэмж, хөнгөлөлт, урамшууллын хэмжээг тогтоох;
 - 6.9.7. Ажилтнуудын ажил үүргийн хуваарийг тогтоох, ажилтныг ажилд авах, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах, дуусгавар болгох;
 - 6.9.8. Хууль тогтоомж, гэрээнд заасан бусад.
- 6.10. Гүйцэтгэх захирал нь дор дурдсан үүрэг хүлээнэ:
- 6.10.1. Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-ийн шийдвэр, тухайн жилийн бизнес төлөвлөгөө, зохицуулагч байгууллагын шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;
 - 6.10.2. Компанийн стратегийн төлөвлөгөө болон эрсдэлийн удирдлага, зохистой засаглалын талаарх дотоод дүрэм, журам, заавар боловсруулж ТУЗ-д танилцуулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулж хангах;
 - 6.10.3. Компанийн үндсэн үйл ажиллагаа болон эрсдэлийн талаарх бүхий л заавар, журам болон стандартыг ажилтнуудаар мөрдүүлэн хэвшүүлэх, энэ талаар зохих гарын авлага болон зөвлөмжөөр хангах;
 - 6.10.4. Компанийн дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэн жигд ажиллагааг ханган ажиллах, үр дүнг тогтмол үнэлэх;
 - 6.10.5. Дотоод хяналтын тогтолцоонд гажуудал үүссэн, эрсдэлийн удирдлагыг хангах талаар тогтоосон үйл ажиллагааны хязгаарлалт зөрчигдсэн бол холбогдох мэдээллийг цаг тухайд нь авч, зохих арга хэмжээг авах;
 - 6.10.6. Компанийн үйл ажиллагааны онцлог болон хүлээж болох эрсдэлийн нэр төрөлтэй уялдаатай удирдлагын мэдээллийн тогтолцоог бий болгох;
 - 6.10.7. Байгууллагын нууцад хамаарах зүйлийн жагсаалтыг батлах;
 - 6.10.8. Компанийн санхүүгийн тайлан, тэнцэл, бусад төрлийн мэдээний үнэн зөвийг хариуцах;
 - 6.10.9. Компанийн санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;
 - 6.10.10. Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах;
 - 6.10.11. Компанийн ажилтнуудын хувьд өөрт ногдсон үүргээ аливаа ашиг сонирхлын зөрчилгүйгээр гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх;
 - 6.10.12. Үүргээ гүйцэтгэх явцад олж авсан компани, үнэт цаасны зах зээлд оролцогч байгууллагын болон хувь хүний нууцад хамаарах мэдээллийг өөрийн, эсхүл гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;
 - 6.10.13. Хувийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлыг хэлэлцэхэд оролцохгүй байх;
 - 6.10.14. Өөрт нь болон өөрийн нэгдмэл сонирхол бүхий этгээдэд компанитай бизнесийн харилцаанд орсон этгээдийн санхүүгийн үр дүнг сонирхох шалтгаан

байгаа бол сонирхлын зөрчил байна гэж үзэж, энэ тухайгаа ТУЗ, түүний нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдэх;

6.10.15. Хууль тогтоомж болон гэрээнд заасан бусад.

- 6.11. Гүйцэтгэх захирал нь үйл ажиллагааны стратеги, бизнес төлөвлөгөөнд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах талаар хүлээсэн үүргээ санаатай тасалдуулсан, энэхүү дүрэм, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, тэдгээрийг ноцтой зөрчсөн тохиолдолд ТУЗ түүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх асуудлыг шийдвэрлэж тогтоол гаргана. Гүйцэтгэх захирал нь ажлаас чөлөөлөгдөхдөө хүндэтгэн үзэхээс бусад тохиолдолд үүрэгт ажлаа өөрийн биеэр биечлэн хүлээлгэн өгнө.
- 6.12. Гүйцэтгэх захиралд компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнд хүлээлгэх хариуцлагын талаар энэхүү дүрэмд заасан зохицуулалт нэгэн адил хамаарах бөгөөд ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан бол гэрээ дуусгавар болсонтой холбоотой үл өрсөлдөх, ажилтан урвуулахгүй байх үүрэг хүлээнэ.

Компанийн эрх бүхий албан тушаалтан, хүлээх хариуцлага

- 6.13. Компанийн эрх бүхий албан тушаалтанд ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Газрын захирлууд, Ерөнхий нягтлан бодогч болон тэдгээртэй адилтгах албан тушаалтан хамаарна.
- 6.14. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй:
- 6.14.1. Компанийн тухай хууль, энэхүү дүрэм, ТУЗ-өөс баталсан дотоод журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримтална;
 - 6.14.2. Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг компанид гаргаж өгнө;
 - 6.14.3. Компанийн нууцад хамаарах мэдээ, тайлан, гэрээ, баримт бичиг, материалыг бусдад дамжуулах, задруулахаас сэргийлэх бөгөөд хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй;
 - 6.14.4. Шийдвэр гаргах, шийдвэр гаргах ажиллагаанд оролцохдоо холбогдох бүх баримт бичиг, мэдээллийг бүрэн судалж, шийдвэрийн үндэслэлд бүрэн итгэлтэй байх;
 - 6.14.5. Шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн бол энэ тухайгаа заавал мэдэгдэж, шийдвэр гаргахад оролцохгүй байх;
 - 6.14.6. Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гуравдагч этгээдээс бэлэг урамшуулал авахгүй, аливаа хэлбэрээр нөлөөнд автахгүй байх.
- 6.15. Эрх бүхий албан тушаалд нэр дэвших үедээ өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэрсийн жагсаалтыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад гарсан өөрчлөлтийн талаар өөрчлөлт гарснаас хойш 10 хоногийн дотор мэдэгдэж байна.
- 6.16. Эрх бүхий албан тушаалтан нь Дүрмийн 6.14-т заасан үүргээ биелүүлээгүйн улмаас компанид хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.
- 6.17. Компанийн эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг Компанийн тухай хууль, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, эрх бүхий албан тушаалтантай байгуулсан онцгой нөхцөл бүхий болон хөдөлмөрийн гэрээ,

компанийн дотоод журмын дагуу шийдвэрлэх бөгөөд боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

- 6.18. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь компанитай байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол албан тушаалаасаа өөрчлөгдсөнөөс хойш 3 жилээс доошгүй хугацаанд компанийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, хувийн сонирхлын зорилгоор ашиглахыг хориглоно.

ДОЛДУГААР БҮЛЭГ. ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Хяналтын зөвлөл

- 7.1. Компани нь хууль болон компанийн дүрэмд хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуулийн дагуу хамгаалах, хувьцаа эзэмшигчдээс компанийн үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан гомдлыг хүлээн авч санал, дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий Хяналтын зөвлөлтэй байна.
- 7.2. Хяналтын зөвлөл нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс бусад хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл бүхий 3 (гурав) гишүүний бүрэлдэхүүнтэй байна.
- 7.3. Хяналтын зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 2 (хоёр) жил хүртэл байх бөгөөд Хяналтын зөвлөлийн гишүүнийг улируулан сонгохгүй.
- 7.4. Хяналтын зөвлөлийн гишүүнийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгоно.
- 7.5. Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нь дараах үндсэн шаардлагыг хангасан хувьцаа эзэмшигч иргэн байна. Үүнд:
- 7.5.1. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй байх;
 - 7.5.2. Компанитай сүүлийн 2 (хоёр) жилийн хугацаанд хөдөлмөрийн харилцаанд оролцоогүй байх;
 - 7.5.3. Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг зохицуулалттай этгээдийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан, эсхүл түүний холбогдох этгээд бус байх;
 - 7.5.4. Бусад арилжаа эрхлэх байгууллагын хувьцаа эзэмшигч, эсхүл түүний холбогдох этгээд бус байх;
 - 7.5.5. Банк, санхүү, эрх зүй, эдийн засаг, бизнесийн чиглэлээр дээд боловсролтой, мэргэшсэн, мэргэжлээрээ 5 (тав)-аас доошгүй жил ажилласан мэдлэг, туршлагатай байх;
 - 7.5.6. Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өр төлбөргүй байх;
 - 7.5.7. Гэмт хэрэгт шүүхийн шийдвэрээр гэм буруутай нь тогтоогдож байгаагүй байх.
- 7.6. Энэхүү дүрмийн 7.5-д заасан шаардлагыг хангаж буй этгээдийг Хяналтын зөвлөлийн гишүүнээр сонгуулахаар тухайн этгээд өөрөө, эсхүл компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч бус хувьцаа эзэмшигч нэр дэвшүүлэх эрхтэй.
- 7.7. Нэр дэвшигчийн материалыг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо хүлээн авч хянаж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлнэ.

- 7.8. Нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан хүнийг Хяналтын зөвлөлийн гишүүнээр сонгоно.
- 7.9. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүд чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан компанийн зүгээс танилцуулсан болон бусад шугамаар олж авсан хуульд заасны дагуу компани, түүний харилцагч болон гуравдагч этгээдийн “нууц” гэж үзсэн аливаа мэдээлэл болон дотоод мэдээллийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байх, шууд болон шууд бус байдлаар бусдад задруулахгүй байх, гуравдагч буюу хөндлөнгийн этгээдэд дамжуулахгүй байх үүрэгтэй.
- 7.10. Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтооно.

Дотоод хяналт

- 7.11. Компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг ТУЗ өөрийн Аудитын хороогоор дамжуулан хэрэгжүүлнэ.
- 7.12. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооноос санал болгосноор Гүйцэтгэх захирлын томилсон Дотоод хяналтын алба хэрэгжүүлнэ.
- 7.13. Дотоод хяналтын алба нь компанийн үндсэн үйл ажиллагааны технологи, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, санхүү, нягтлан бодох бүртгэл, эрх зүйн мэдлэг, туршлагатай ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Гүйцэтгэх захирлын баталсан Дотоод хяналтын журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна.
- 7.14. Гүйцэтгэх захирлын зөвлөлийн хуралдаанаар Дотоод хяналтын албаны мэдээлэл, шалгалтын дүнг улирал бүр хэлэлцэн, холбогдох арга хэмжээг авна.
- 7.15. Дотоод хяналтын албаны ажилтан ажлын байранд хэзээ ч нэвтрэх, аливаа мэдээллийг шаардан гаргуулах эрхтэй байна.

Хөндлөнгийн аудит

- 7.16. Аудитын тухай хуульд заасны дагуу компанийн санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх хөндлөнгийн аудитын байгууллагыг ТУЗ сонгож, түүнтэй заавал гэрээ байгуулж ажиллуулна.
- 7.17. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг батална.
- 7.18. Дараах этгээдийг компанийн хөндлөнгийн аудиторoor сонгон ажиллуулахыг хориглоно:
 - 7.18.1. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн болон нэгдмэл сонирхолтой компанийн эрх бүхий албан тушаалтан;
 - 7.18.2. Компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас, эсхүл компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрх эзэмшдэг;
 - 7.18.3. ТУЗ-өөс тухайн этгээд нь дотоод аудиторoor ажиллахад харшилна гэж үзсэн үндэслэл бүхий бусад нөхцөл.

- 7.19. Аудитын байгууллагатай байгуулах гэрээнд компанийн болон аудитын байгууллагын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээг заасан байна.
- 7.20. Аудитын шалгалт нь ээлжит болон ээлжит бус байна.
- 7.21. Компанийн санхүүгийн жилийн тайланг баталгаажуулахын тулд ээлжит шалгалт хийнэ.
- 7.22. Ээлжит бус шалгалтыг ТУЗ, эсхүл нийт хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигчдийн шаардлагаар хэдийд ч хийж болно.
- 7.23. Шалгалтын явцад эрх бүхий албан тушаалтан компани болон хувьцаа эзэмшигчдэд хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээд төлөх бөгөөд бусад тохиолдолд компани өөрөө, эсхүл шаардлага тавьсан талууд хариуцна.

Их хэмжээний хэлцэл

- 7.24. Их хэмжээний хэлцэлд дараах хэлцлийг ойлгоно. Үүнд:
 - 7.24.1. Хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/;
 - 7.24.2. Компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг, эсхүл энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт.
- 7.25. Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг ТУЗ-ийн саналын эрхтэй гишүүд санал нэгтгэйгээр гаргана.
- 7.26. ТУЗ их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг санал нэгтгэйгээр гаргаж чадахгүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 7.27. Их хэмжээний хэлцлийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ тогтооно.
- 7.28. Их хэмжээний хэлцэл мөн эсэхийг тодорхойлохдоо ТУЗ нь Аудитын зөвлөмжийн дагуу эд хөрөнгийн балансын үнийг инфляцын /мөнгөний ханшийн уналт/ түвшинтэй уялдуулан шинэчлэн тогтоож болно.

Сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийх хэлцэл

- 7.29. Нэгдмэл сонирхолтой этгээд, түүнтэй хийх хэлцлийг тодорхойлох, компанийн үйл ажиллагаан дахь сонирхлын зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг тусад нь журмаар зохицуулна. Уг журмыг ТУЗ батална.
- 7.30. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь уг хэлцлийн талаар шийдвэр гаргахад санал өгөх эрхгүй байна.
- 7.31. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүдийн олонхын саналаар гаргана.

- 7.32. Компани өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхогч этгээд үзэх боломжийг хангах үүрэгтэй.
- 7.33. Компани тухайн тайлангийн хугацаанд байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцлийн тоо, хэлцэл хийсэн этгээд, хэлцлийн үнийн дүнгийн талаарх мэдээллийг тухайн жилийн тайланд тусган нийтэд мэдээлэх үүрэгтэй.

НАЙМДУГААР БҮЛЭГ. БУСАД

Ногдол ашиг хуваарилан олгох

- 8.1. ТУЗ нь ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргах бөгөөд уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг тусгана.
- 8.2. Ижил төрлийн хувьцаа бүрийн хувьд нэгж хувьцааны ногдол ашгийн дүн нь хувьцаа бүрийн хувьд адил байна.
- 8.3. Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.
- 8.4. ТУЗ нь ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнах үүрэгтэй.
- 8.5. Компани нь хууль тогтоомжид заасан бүх нөхцөл биелэгдсэн тохиолдолд энгийн хувьцаанд хамаарах ногдол ашгийг хуваарилж болно.
- 8.6. Компани нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд уг шийдвэрт заасан хугацаанд ногдол ашгийг хуваарилна. Энэ хугацаанд ногдол ашгаа аваагүй нь тухайн хувьцаа эзэмшигчийн ногдол ашиг авах эрхийг үгүйсгэх, эсхүл компани ногдол ашиг олгохгүй байх үндэслэл болохгүй.
- 8.7. Хуваарилахаар шийдвэрлэсэн ногдол ашгийг ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигч бүрээр түүнд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэрээр тусгайлан бүртгэж хадгалах бөгөөд компани хувьцаа эзэмшигчийн анхны шаардлагаар ногдол ашгийг олгох үүрэгтэй.
- 8.8. Компани нь ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг Хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.
- 8.9. ТУЗ нь ногдол ашиг хуваарилалтын тайланг хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд заавал тайлагнана.
- 8.10. Хувьцаа эзэмшигч ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах буюу бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэл хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлсэн тохиолдолд ногдол ашиг авах эрх нь тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол уг хувьцааны хуучин эзэмшигчид үлдэнэ.
- 8.11. ТУЗ нь Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, энэ дүрэмд нийцүүлэн Ногдол ашгийн бодлогыг батална.

Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл тайлан

- 8.12. Компанийн санхүүгийн жилийн эхлэх, дуусах хугацаа нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл байна.
- 8.13. Компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан болон эрх бүхий байгууллагын журмаар тогтоосон мэдээ, тайлангийн үнэн зөвийг компанийн Гүйцэтгэх захирал хариуцна.
- 8.14. Санхүүгийн мэдээллийн үнэн зөвийг Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч хамтран хариуцна.
- 8.15. ТУЗ нь компанийн санхүүгийн тайлангийн талаарх хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна.
- 8.16. Компани Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон нэмэлт, мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт тогтоосон хугацаанд хүргүүлж байх үүрэгтэй.

Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах

- 8.17. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг Компанийн тухай хууль, энэ дүрэмд заасны дагуу шийдвэрлэнэ.
- 8.18. Компанийг дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хуульд заасан журмаар татан буулгана.
 - 8.18.1. Компанийн үйл ажиллагаа алдагдалтай байгаагаас цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон;
 - 8.18.2. ТУЗ нь компанийг татан буулгах комисс томилох, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулсны дараа компанид үлдэх эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах журам зэргийг тусгасан татан буулгах төслийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонх зөвшөөрсөн;
 - 8.18.3. Хуульд заасан бусад үндэслэлээр.

Дүрэм хүчин төгөлдөр болох

- 8.19. Энэхүү дүрэм нь компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталж, улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 8.20. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэхийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор батлах бөгөөд тухайн нэмэлт, өөрчлөлт нь улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

MONGOLIAN
STOCK EXCHANGE

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. БУСАД

Үнэт цаас худалдах, эргүүлэн авах

- 9.1. Компани давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг зохих хууль журамд заасны дагуу гаргаж болно.
- 9.2. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр, эсхүл Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон журмын дагуу худалдан авч болох бөгөөд энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.
- 9.3. Компани нь энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь худалдан авч болох бөгөөд харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджийн 25 хувиас хэтэрч болохгүй.
- 9.4. Компани нь үнэт цаас эргүүлэн худалдан авахдаа худалдаж байгаа этгээдтэй тохиролцсоны дагуу түүний төлбөрийг бэлэн мөнгө, үнэт цаас болон эд хөрөнгийн бусад хэлбэрээр хийж болно.



MONGOLIAN
STOCK EXCHANGE

ТӨСӨЛ

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн
Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2023 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дүгээр тогтоолын хавсралт

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар “Монголын хөрөнгийн бирж” ХК (цаашид “МХБ” гэх)-ийн Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны чиглэл, хэлэлцэх асуудал, ажиллах хэлбэртэй холбоотой харилцаа болон холбогдох бусад харилцааг зохицуулна.

1.2. Хяналтын зөвлөл (цаашид “зөвлөл” гэх) нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо, өөрийгөө зохицуулах байгууллагаас баталсан холбогдох журам, бодлогын баримт бичиг, МХБ-ийн дүрмийг үйл ажиллагаандаа удирдлага болгоно.

Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүн, хугацаа

2.1. Зөвлөл нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс бусад хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл бүхий 3 (гурав) гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд зөвлөлийн гишүүнийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн сонгоно.

2.2. Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нь дараах үндсэн шаардлагыг хангасан хувьцаа эзэмшигч иргэн байна. Үүнд:

- 2.2.1. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй байх;
- 2.2.2. Компанитай сүүлийн 2 (хоёр) жилийн хугацаанд хөдөлмөрийн харилцаанд оролцоогүй байх;
- 2.2.3. Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг зохицуулалттай этгээдийн эрх бүхий албан тушаалтан, ажилтан, эсхүл түүний холбогдох этгээд бус байх;
- 2.2.4. Бусад арилжаа эрхлэх байгууллагын хувьцаа эзэмшигч, эсхүл түүний холбогдох этгээд бус байх;
- 2.2.5. Банк, санхүү, эрх зүй, эдийн засаг, бизнесийн чиглэлээр дээд боловсролтой, мэргэшсэн, мэргэжлээрээ 5 (тав)-аас доошгүй жил ажилласан мэдлэг, туршлагатай байх;
- 2.2.6. Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өр төлбөргүй байх;
- 2.2.7. Гэмт хэрэгт шүүхийн шийдвэрээр гэм буруутай нь тогтоогдож байгаагүй байх.

2.3. Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 2 (хоёр) жил хүртэл байх бөгөөд хяналтын зөвлөлийн гишүүнийг улируулан сонгохгүй.

2.4. Зөвлөлийн гишүүдийг дор дурдсан журмаар сонгоно. Үүнд:

- 2.4.1. Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх хүсэлтийг хүлээн

авах зарыг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдахаас 40 (дөч)-өөс доошгүй хоногийн өмнө өөрийн цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэнэ.

- 2.4.2. Энэхүү журмын 2.2-т заасан шаардлагыг хангасан хувьцаа эзэмшигч иргэн нэр дэвших хүсэлтээ Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх зард дурдсан баримт бичгийн хамтаар ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороонд ирүүлнэ.
- 2.4.3. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нэр дэвшигчийн баримт бичгийг хүсэлтийн хамт хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлахаас 10 (арав)-аас доошгүй хоногийн өмнө хүлээн авч хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын дүрэм, журам, компанийн дүрэм, бусад холбогдох журамд заасан шаардлагыг хангасан эсэх талаар нэр дэвшигч бүрээр дүгнэлт гарган Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нэр дэвшүүлэн танилцуулж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар “нэг хувьцаа нэг саналын эрхтэй байх” зарчмаар санал хураах хуудсаар санал хурааж шийдвэрлүүлнэ.
- 2.4.4. Энэ журмын 2.4.3-т заасны дагуу хамгийн олон санал авсан 3 (гурав) нэр дэвшигчийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолоор зөвлөлийн гишүүнээр томилж, урамшууллын хэмжээг тогтооно.

2.5. Зөвлөлийн даргыг Зөвлөлийн гишүүд дотроосоо олонхын саналаар сонгоно.

Гурав. Зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл

- 3.1. Зөвлөл нь МХБ-ийн дүрмийн долоодугаар бүлэгт заасан хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуулийн дагуу хамгаалах, хувьцаа эзэмшигчдээс гаргасан гомдлыг хүлээн авч санал, дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүрэгтэй байна.
- 3.2. Зөвлөл нь энэхүү журмын 1.1 дэх хэсэгт заасны дагуу дараах чиг үүргийг хэрэгжүүлж, санал, дүгнэлт, зөвлөмж гаргана. Үүнд:
 - 3.2.1. Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хуулийн дагуу хамгаалах чиглэлээр санал гаргаж ТУЗ-д хүргүүлэх;
 - 3.2.2. Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн гомдлын хүрээнд дүгнэлт, зөвлөмж гаргаж, ТУЗ-д хүргүүлэх;
 - 3.2.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу зөвлөмж гаргаж, компанийн Гүйцэтгэх захиралд хүргүүлэх.
- 3.3. Зөвлөл чиг үүргээ хараат бус байдлаар хэрэгжүүлэх бөгөөд зөвлөлийн үйл ажиллагаанд бусад хувьцаа эзэмшигч, ТУЗ, Гүйцэтгэх удирдлага хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.


Дөрөв. Зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр

- 4.1. Зөвлөлийн үйл ажиллагаа нь байнгын бус байх бөгөөд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх үндсэн хэлбэр нь хурал байна.
- 4.2. Зөвлөлийн хурлыг дараах тохиолдолд Зөвлөлийн дарга зарлан хуралдуулна. Үүнд:
 - 4.2.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга санал гаргасан, эсхүл өөрийн санаачилгаар;

- 4.2.2. Хувьцаа эзэмшигчдээс санал, гомдол гаргасан;
 - 4.2.3. ТУЗ-өөс хүсэлт гаргасан;
 - 4.2.4. Зөвлөлийн 2 буюу түүнээс дээш гишүүн санал гаргасан.
- 4.3. Зөвлөлийн хурлыг биечлэн болон цахимаар хуралдуулж болно.
- 4.4. Зөвлөлийн хуралд зөвлөлийн гишүүн биечлэн оролцох үүрэгтэй бөгөөд хуралд зөвлөлийн нийт гишүүдийн олонх нь оролцсоноор хүчин төгөлдөрт тооцно.
- 4.5. Зөвлөлийн хуралд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас биечлэн оролцох боломжгүй зөвлөлийн гишүүн цахимаар оролцож болно.
- 4.6. Зөвлөлийн хуралд шаардлагатай тохиолдолд компанийн гүйцэтгэх удирдлага, хэлэлцэж буй асуудалтай холбогдох нэгжийн удирдлага болон ажилтнуудыг оролцуулж болно.
- 4.7. Зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцан гүйцэтгэх бөгөөд хурал зохион байгуулах, тэмдэглэл хөтлөх, санал, дүгнэлтийг албажуулах, холбогдох этгээдэд хүргүүлэх зэрэг асуудлыг хариуцна.
- 4.8. Зөвлөлийн дарга хурлын тов, хэлэлцэх асуудлыг хурал хуралдах өдрөөс ажлын 3 (гурав)-аас доошгүй өдрийн өмнө тогтоож, хурлаар хэлэлцүүлэх асуудлыг холбогдох этгээд ажлын 4 (дөрөв)-өөс доошгүй хоногийн өмнө ТУЗ-ийн нарийн бичгийн даргад холбогдох иж бүрдлийг ханган ирүүлсэн байна.
- 4.9. Хурлаар хэлэлцүүлэх асуудалд холбогдох материалыг хурал эхлэхээс хоёроос доошгүй хоногийн өмнө зөвлөлийн гишүүдэд хүргүүлнэ.
- 4.10. Зөвлөлийн хурлыг дараах дэгийн дагуу явуулна. Үүнд:
- 4.10.1. Зөвлөлийн хуралд хэлэлцүүлэх асуудлыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, эсхүл зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлага, шууд хариуцах нэгжийн захирал, холбогдох ажилтнууд танилцуулна;
 - 4.10.2. Зөвлөлийн гишүүн нь хэлэлцэж буй асуудалд холбогдох асуулт асууж, хариулт авсны дараа тухайн хэлэлцэж буй асуудлыг хангалттай хэмжээний мэдээлэлтэй болсны эцэст санал өгнө;
 - 4.10.3. Зөвлөлийн гишүүн нэг саналын эрхтэй байна;
 - 4.10.4. Зөвлөлийн шийдвэрийг зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар гаргах бөгөөд зөвлөлийн шийдвэр нь санал, дүгнэлт, зөвлөмж хэлбэртэй байна.
- 4.11. Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлын тэмдэглэлд бүх гишүүд гарын үсэг зурна. Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудалд эсрэг саналтай байсан гишүүн энэ тухайгаа тэмдэглэл үйлдэн гарын үсэг зурна.
- 4.12. Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлын талаар гаргаж буй санал дүгнэлт, зөвлөмжид зөвлөлийн дарга гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 4.13. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсанд зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл, эрхэлсэн асуудалд холбогдох бодлогын баримт бичиг, бүтэц бүрэлдэхүүний мэдээлэл, хурлын давтамж, хэлэлцсэн асуудал, ирцийг нийтэд мэдээлнэ.
- 4.14. Зөвлөлийн дарга, гишүүд Компанийн нууцын зэрэглэлд багтах баримт бичигтэй ажлын байранд биечлэн ирж танилцана.
- 4.15. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангуулах, шаардлагатай мэдээ, мэдээлэл, тайлан, баримт бичгийг саадгүй гаргуулах авах, холбогдох мэдээ, мэдээлэл, тайлан, баримт бичгийг зөвлөлийн тогтоосон хугацаанд гаргаж өгөөгүй ажилтанд хариуцлага тооцох саналыг компанийн гүйцэтгэх удирдлагад гаргана.

Тав. Хяналт, хариуцлага, тайлагнал

- 5.1. Зөвлөлийн үйл ажиллагаанд хувьцаа эзэмшигчдийн хурал хяналт тавьж ажиллана.
- 5.2. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүд чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан компанийн зүгээс танилцуулсан болон бусад шугамаар олж авсан хуульд заасны дагуу компани, түүний харилцагч болон гуравдагч этгээдийн “нууц” гэж үзсэн аливаа мэдээлэл, болон дотоод мэдээллийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байх, шууд болон шууд бус байдлаар бусдад задруулахгүй байх, гуравдагч буюу хөндлөнгийн этгээдэд дамжуулахгүй байх үүрэгтэй.
- 5.3. Зөвлөлийн үйл ажиллагааны жилийн тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд зөвлөлийн дарга танилцуулна.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 59

Улаанбаатар хот

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн
арилжааг "Монголын хөрөнгийн бирж"
ТӨХК-аар гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 11 дэх хэсэг, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-аар гүйцэтгүүлсүгэй.

2. "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-аар гүйцэтгүүлэх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх арга хэмжээг Компанийн тухай хуулийн дагуу авч хэрэгжүүлэхийг тус компанийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгаж, Санхүүгийн зохицуулах хороо (Д.Баярсайхан)-д зөвлөсүгэй.

4. Энэ тогтоолыг Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН САЙД

Ж.ГАНБААТАР

ТӨСӨЛ

**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 62.1.15 дахь заалт, 2023 оны 4 дүгээр сарын 28–ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /С.Тулга/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

С.МӨНГӨНЧИМЭГ

**MONGOLIAN
STOCK EXCHANGE**

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн 2022 оны ногдол ашиг
хуваарилалтын тухай

Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.2, 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2022 оны цэвэр ашгийн дүнгээс ногдол ашиг хуваарилах нь Компанийн тухай хууль, компанийн ногдол ашгийн бодлогод тусгагдсан ногдол ашиг хуваарилах нөхцөлийг хангахгүй байх тул Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг дэмжсүгэй.

2. Энэхүү тогтоолыг Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд холбогдох журмын дагуу хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Мөнхзул/-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /С.Тулга/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

С.МӨНГӨНЧИМЭГ

MONGOLIAN
STOCK EXCHANGE

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн
2023 оны зорилтот түвшнийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалт, 2023 оны 4 дүгээр сарын 28–ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг хавсралт ёсоор баталсугай.
2. Батлагдсан зорилтот түвшинд хүрэхэд шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /С.Тулга/-д тус тус даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

С.МӨНГӨНЧИМЭГ

MONGOLIAN
STOCK EXCHANGE

ТӨСӨЛ

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн хувь нийлүүлсэн
хөрөнгийн хэмжээг тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, 2023 оны 4 дүгээр сарын 28–ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын ... дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 350,463,539 /гурван зуун тавин сая дөрвөн зуун жаран гурван мянга таван зуун гучин ес/ ширхэг энгийн хувьцаатай буюу нийт 35,046,353,900 /гучин таван тэрбум дөчин зургаан сая гурван зуун тавин гурван мянга есөн зуу/ төгрөгөөр тогтоосугай.



MONGOLIAN
STOCK EXCHANGE

ТӨСӨЛ

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, "2023 оны 4 дүгээр сарын 28–ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хавсралт ёсоор баталсугай.

2. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг холбогдох хууль, журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /С.Тулга/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

С.МӨНГӨНЧИМЭГ

MONGOLIAN
STOCK EXCHANGE

ТӨСӨЛ

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

Хяналтын зөвлөлийн журмын төслийг
агуулгын хувьд сайшаах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалт, 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан Хяналтын зөвлөлийн журмын төслийг дараагийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр агуулгын хувьд сайшаасугай.

2. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг томилох асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэн батлуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо /...../-нд үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /С.Тулга/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

С.МӨНГӨНЧИМЭГ

**MONGOLIAN
STOCK EXCHANGE**

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 дэх хэсгүүд, 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэг, "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-аар гүйцэтгүүлэх тухай" Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 59 дүгээр тогтоол, "Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх асуудлын тухай" Сангийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01/1036 тоот албан бичиг, 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын ... дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнээр дор дурдсан нэр дэвшигчдийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хүртэл хугацаанд улируулан сонгосугай.

1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр:

- 1.1.1. Д.Баянзул
- 1.1.2. Ч.Дондогмаа
- 1.1.3. Л.Наранчимэг
- 1.1.4. М.Санжаадорж
- 1.1.5. С.Тулга
- 1.1.6. Д.Энхбаатар

1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр:

- 1.2.1. А.Анар
- 1.2.2. А.Батпүрэв
- 1.2.3. Р.Гандиймаа

2. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхтэй холбоотойгоор Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан хуралдуулж, компанийн Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцүүлэн, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг дахин сонгосугай.

3. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нийцүүлсэн байдлаар компанийн Дүрмийн төсөл боловсруулан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэхийг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д даалгасугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар сонгох Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг холбогдох хууль, журмын дагуу сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хороо /...../-нд даалгасугай.

5. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангуулж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж, зохих зөвшөөрлийг авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Мөнхзул/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

С.МӨНГӨНЧИМЭГ



MONGOLIAN
STOCK EXCHANGE

САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 4-р сарын 17-өдрийн 15 дугаар
тогтоолын 4 дүгээр хавсралт

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ТӨХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овогНэр.....

Регистрийн дугаар

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн тоо:

Бүртгэсэн / Үнэт цаасны компани /

Брокерийн овог: нэр:

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 09:00 цагт болно.

Дараах хэлэлцэх асуудлуудад ЕРДИЙН АРГААР санал хураана.

Саналын хуудас бөглөх заавар: Ердийн журмаар саналаа өгөхөд асуудал бүрээр "зөвшөөрсөн", "татгалзсан", "түдгэлзсэн" аль нь болохыг ✓ тэмдэглэж санал болгоны ард гарын үсгээ зурна.

№	ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ	Санал авах арга	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал	Гарын үсэг
1.	Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах	Ердийн	Тогтоол №1	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
2.	Ногдол ашиг хуваарилах эсэх талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн үндэслэлтэй танилцах		Тогтоол №2	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
3.	Компанийн 2023 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж, батлах		Тогтоол №3	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
4.	"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох		Тогтоол №4	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
5.	"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэж, батлах		Тогтоол №5	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
6.	"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг танилцах		Тогтоол №6	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		

7.	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн талаар авах зарим арга хэмжээний талаар хэлэлцэж, шийдвэрлэх		Тогтоол №7	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		
----	---	--	------------	--------------------------	--------------------------	--------------------------	--	--

Саналын хуудсыг бүртгэж, хүлээн авсан албан тушаалтны гарын үсэг, гарын үсгийн тайлал:
..... / /

2023 оны ____ сарын ____ өдөр

САНАЛ АВАХ ХУУДСЫГ БӨГЛӨХ САНАМЖ

Саналын хуудсыг дараах зааврын дагуу бөглөнө.

- Та саналаа урьдчилсан байдлаар цаасан хэлбэрээр өгөх бол өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компаниар дамжуулан эсвэл Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Д.Сүхбаатарын талбай 3 хаяг байрлах Монголын хөрөнгийн биржийн байр, цахим хэлбэрээр өгөх бол Монголын хөрөнгийн биржийн www.mse.mn цахим хуудсаар өгч болно.
- Та урьдчилан санал өгсөн бол дахин тухайн асуудалд санал өгөх эрхгүй.
- Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн санал өгч байгаа бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулах ба тухай саналын хуудсыг итгэмжлэлийн хамт хүчинтэйд тооцно.
- Саналыг ердийн аргаар тоолох асуудалд:
 - Та саналын хуудсыг бөглөхдөө тухайн асуудалд зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн гэсэн аль нэгд нь ✓ эсвэл + тэмдгээр саналаа өгнө.
 - Засварласан, балласан эсвэл аль нэг саналыг бөглөөгүй бол саналын хуудсыг хүчингүйд тооцно.** Та саналаа урьдчилсан байдлаар цаасан хэлбэрээр өгөх бол өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компаниар дамжуулан эсвэл Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Д.Сүхбаатарын талбай 3 хаяг байрлах Монголын хөрөнгийн биржийн байр, цахим хэлбэрээр өгөх бол Монголын хөрөнгийн биржийн www.mse.mn цахим хуудсаар өгч болно.
 - Та урьдчилан санал өгсөн бол дахин тухайн асуудалд санал өгөх эрхгүй.
 - Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн санал өгч байгаа бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулах ба тухай саналын хуудсыг итгэмжлэлийн хамт хүчинтэйд тооцно.

Энэ хэсгийг Тооллогын комисс бөглөнө.

Хэлэлцэх асуудал № саналыг хүчинтэйд тооцов.

Тооллогын комиссын даргын гарын үсэг, гарын үсгийн тайлал:..... / /

Хэлэлцэх асуудал № саналыг хүчингүйд тооцсон шалтгаан:

.....
.....
.....

~o0o~